

АВСТРИ-ДОРНЫН УЛС

*Л.Бэгзжав**

Төв Европын Бүгд Найрамдах Австри Улстай Төв Азийн Монгол Улс дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ой 2003 оны долдугаар сарын 1-нд тохиолоо. БНАУ нь өрнөдийн орнуудаас анхлан Монгол Улстай дипломат харилцаа тогтоосон орны нэг билээ. 2003 оны долдугаар сарын эхээр Монгол Улсын төрийн тэргүүн анх удаа БНАУ-д албан ёсны айлчлал хийсэн нь Монгол-Австрийн харилцааг шинэ шатанд гаргаж, урагшлуулан хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан түүхэн үйл явдал болов. Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди БНАУ-ын Холбооны Ерөнхийлөгч Томас Клестил нар хоёр улс цаашид худалдаа, эрүүл мэнд, байгаль орчин, аялал жуулчлал, боловсролын салбарт хамтран ажиллах өргөн боломж байгааг харилцан тэмдэглэсэн байна¹.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандийн айлчлалын үеэр, хоёр талын харилцааны эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд хувь нэмэр болох баримт бичгүүдэд хоёр тал гарын үсэг зурж, Австрийн нийслэл Вена хотод Монгол Улс Элчин сайдын Яамаа нээсэн нь хоёр орны харилцааны түүхэнд тэмдэглэлт шинэ хуудас нээв. 2003 оны 8-р сард Австрийн тал Монгол Улсад Консулын газар нээлээ. Мөн МУИС-ийн ОУХДС-ийн дэргэд “Австри номын сан”, “Австри судлалын төв” байгуулагдсан нь хоёр орны соёлын харилцааны содон үйл явдлын нэг болов.

Монгол-Австрийн харилцааны 40 жилийн түүхийг тодотгон, нарийвчлан судлах нь маргаангүй хийгдэх учиртай ажил төдийгүй хоёр орны харилцааны ирээдүйг тодорхойлоход ч чухал хүчин зүйл болох юм.

Анх удаа МЭ 996 онд “Австри” гэдэг нэр түүхэнд тэмдэглэгджээ. Тухайн үед Төв Европод оршин тогтнож байсан хаант улсын зүүн хязгаарыг Австри хэмээн нэрийдсэн нь латин хэлний дорнын хязгаар, дорнын газар нутаг гэсэн утгатай ажээ². 1156 онд энэхүү зүүн хязгаарт герман, словени, унгар үндэстний тэмцлийн гал дундаас Австрийн вант улс /марк граф/ үүсэн байгуулагджээ. Латин хэлээр Austria, эртний герман хэлээр Ostarrich³ /өдгөө Österreich/ гэсэн үг латинжсан дуудлагаар англи хэлэнд Austria гэж орсноор өнөөгийн Австри улсын нэр үүссэн ажгуу. 1278 онд Австрид тогтсон Габсбург вангийн ноёрхол

*Л.Бэгзжав - доктор (Ph.D), дэд профессор

нь 640 жил үргэлжилж, Австри нь түүхэн цаг үеийн ээдрээнд нэгдэн, задарч, дайн самуунд өртөж явсаар XX зууны эхэнд дэлхийн I дайны дараа Австри-Унгарын хаант улс задарсанаар бие даасан Бүгд Найрамдах улс байгуулагджээ. 1938 оны 3-р сард Австрийг Гитлерийн Герман улс эзэлж, Герман-Италийн эзэнт улсад нэгдсэн юм. Дэлхийн II дайнд Австри нь Германы талд байлдсан бөгөөд 1945 оны 4-р сард Зөвлөлтийн арми Вена хотыг чөлөөлсөний дараа Холбоотны арми Австрийн нутаг дэвсгэрийг ЗХУ, АНУ, Англи, Францын гэж 4 бүсэд хуваан эзэмшжээ. 1955 оны 5-р сард дурдсан 4 гүрэн хамтран “тусгаар тогтносон, ардчилсан Австри улсыг ахин байгуулах гэрээ”-нд гарын үсэг зурж, мөн оны 10-р сард тэдгээр орон Австриас цэргээ гаргаснаар Австри улс дахин тусгаар тогтносон улс болов. 1955 оны 10-р сарын 26-нд Австрийн парламент тус улс “байнгын төвийг сахисан” орон болох тухай хууль баталж, аливаа нэг цэргийн эвсэл холбоонд оролцохгүй, нутаг дэвсгэр дээрээ гадаадын цэргийн бааз байгуулахгүй байх үүрэг авчээ. 1965 оноос эхлэн жил бүрийн 10-р сарын 26-ны өдрийг Австрийн улсын баяр болгон тэмдэглэх болсон байна.

Австри улс нь 2001 оны тоо бүртгэлээр, 8.6 сая хүн амтайгаас 98-аас дээш хувь нь герман хэлээр ярьдаг⁴ хүн амын дотор гадаадын хүн 748 мянга буюу хүн амын 9,2%-ийг эзэлж байна. Үндэстний цөөнх болох словени, каледони, унгар зэрэг хүмүүс хүн амын 0,52%-ийг эзэлдэг⁵. Герман хэл албан ёсны хэл нь болдог Австрийн хүн ам манай улсынхаас даруй 3,3 дахин олон боловч, газар нутгийн хэмжээгээр бараг 19 дахин бага буюу Орхон аймгийн нутагтай ойролцоо, Өмнөговь аймгийн нутаг Австрийнхаас 2 дахин том юм. Энэ нь 83858 км² бөгөөд 1м² газарт 34 хүн ноогддог⁶. Австричуудыг консерватив үзэлтэй, үнэн сүсэгтэй, маш нөхөрсөг, боловсон, ёсорхог ард түмэн гэлцдэг. Улсын хэмжээний 10 том баяр нь шашны үүсэлтэй.

Австрийн одоогийн мөрдөж буй Үндсэн хуулийг 1920 онд баталж, 1925, 1929 онд 2 удаа нэмэлт оруулж, 1934 онд хүчингүй болгосон ч 1945 онд Австри улс дахин байгуулагдахад анхны Үндсэн хуулиа хожим оруулсан нэмэлттэй нь хүчин төгөлдөр хэмээн хэрэгжүүлж байна.

Энэхүү Үндсэн хууль ёсоор Австри нь Холбооны байгууламжтай, БНУ бөгөөд ерөнхийлөгч бол Улсын тэргүүн, бүх нийтийн сонгуулиар 6 жилийн хугацаатай сонгогддог. Одоогийн Ерөнхийлөгч Т.Клестил 1992, 1998 онд 2 удаа ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж байна.

Хууль тогтоох дээд байгууллага Парламент нь Үндэсний зөвлөл, Холбооны зөвлөл гэсэн 2 танхимтай. Австрийн одоогийн Засгийн газрыг 2002 оны 2-р сард Ардын нам, Чөлөөт нам хамтран эмхлэн зохион

байгуулсан ба Засгийн газрын тэргүүн нь Холбооны канцлер буюу Ерөнхий сайд Вольфанг Шюссал юм.

Австри эдийн засгийн өндөр хөгжилтэй орны нэг боловч 1995 оноос эдийн засаг нь зогсонги байдалд орж, 1997 оноос сэргэж эхэлжээ. 2000 онд эдийн засгийн өсөлт нь 3,3 % болон өсч, мөнгөний ханш өсөлт бууран, ажилгүйдлийн тоо багасчээ. Бал чулуу, магни, төмөр, газрын тос, байгалийн хий зэрэг ашигт малтмалын нөөц ихтэй Австри улс ой мод, усны эрчим хүчний ихээхэн баялагтай тул энэ салбарт Монгол Улстай хамтран ажиллах өргөн бололцоотой. Энэ талаар хоёр улс ярилцан тохиролцсон зүйл цөөнгүй бий. Газар нутгийн 42 % нь ой мод эзэлдэг, ойн талбай нь 4 сая га, модны нөөцийн хэмжээ нь 990 сая шоо метр аж.

Тайван цагт 52 мянган цэргийн албан хаагчтай Австрид дайчилгааны анги буюу 150 мянган журамт цэрэг бий. Батлан хамгаалах зардал нь дотоодын үйлдвэрлэлийн нийт өртөгийн 0,80 %-ийг эзэлдэг байна.

Ард түмний аж амьдралын тухайд гэвэл Австри улсын хэмжээнд даатгал ба халамжийн систем үйлчилдэг. Гол нь эмнэлэг, ажилгүйдэл, тэтгэвэр, ослын гэсэн 4 төрлийн том даатгалтай. Австри бол “өндөр настны орон”, тус орны эрчүүдийн дундаж нас 75,91, эмэгтэйчүүдийнх бүр өндөр буюу 81,68⁶. Тус улсад төрөлт жилээс жилд багасч байгаа учраас хүн ам хөгшрөх үйл явц ноцтой үзэгдэл болоод байгаа аж. Австричууд гэр бүлээ хүндэтгэх уламжлалтай ч залуучууд эрт гэрлэн эцэг эхээс тусгаарлан амьдрах нь ихэссэн тул хөгшчүүл асрамжийн газарт очих нь ихэсчээ. 60 нас хүрсэн ахмадууд халамжийн байгууллагад очих бөгөөд 60 хүрээгүй ч өвчний шаардлагаар тэнд очих настанууд олон ажээ. Тоо бүртгэлийн мэдээгээр, Вена хотын халамжийн газарт 70 мянга орчим настан амьдардаг агаад жил бүр 1200 хүн авдаг байна. Тиймээс ч халамжийн төвд очих дараалал ихтэй байдаг байна. Энд нэг хүний байр 1080 евро, /1 евро=13.76 шиллинг/ хоёр хүнийх 1869 еврогийн үнэтэй бөгөөд дулаан, халуун ус, зурагт, цэвэрлэгээ, хоол ундны мөнгө бүгд багтдаг. Австричууд татвар хураамжаа төлөөд дунджаар сардаа 12-1500 еврогийн /1284-1605 ам. дол/ орлоготой гэвэл халамжийн газар амьдрах нь тийм ч хямд биш гэлтэй. Гэвч энд амьдрахад мөнгө зарах шаардлага бараг үгүй аж. Учир нь Австри бол чинээлэг амьдралтай улс, настанууд олон төрлийн хөнгөлөлт эдэлдэг, хэрэглээний зардал маш бага. Тэтгэврийн мөнгө нь хүрэлцэхгүй юм уу, бусад эдийн засгийн эх сурвалж үгүй бол

улсаас тэтгэмж олгодог. Хэрвээ тэд өвдөж зовох бол асрамжийн газарт тусгай хүн асарч сувилж эмчилдэг, гадуур мөнгө зарах хэрэггүй юм байна. Австри улсад нэг хүнд ногдох үндэсний орлого 281790 шиллинг /1 ам. дол.=12,86 шиллинг/ ойролцоогоор 21912 ам. доллар, сарын дундаж цалин нь ажилчин хүнийх 11890 шиллинг буюу 925 ам. доллар, албан хаагчдынх 15591 шиллинг буюу 1212 ам. доллар, төрийн албан хаагчийнх 21427 шиллинг буюу 1666 ам доллар байна. 10 мянган хүн тутмын 456 нь хөнгөн тэрэгтэй гэсэн тоон үзүүлэлт байдаг⁷.

Австрийн боловсролын салбарт онцлох зүйл олон бий. Сургуулийн насны хүүхдүүд 9 жилийн үнэ төлбөргүй сургалтанд хамрагддаг бөгөөд сургалт, ном сурах бичиг, сургуульд ирж очих тээврийн зардлыг улсаас даадаг. Бүрэн дунд сургууль төгсөгчид их сургуульд элсэлтийн шалгалтгүй суралцдаг. Тус улсад сургалтын нийт зардал /1999 он/ 72,9 тэрбум шиллинг байгаа нь улсын дотоодын үйлдвэрлэлийн нийт зардлын 2,68 % болж байгаа юм. Бүх төрлийн, бүх шатны 6289 сургуульд 1,2 сая гаруй сурагч, 20 их сургуульд 233 мянган оюутан суралцаж байна. 1365 онд байгуулагдсан Венийн их сургууль бол дэлхийн ууган их сургуулиудын нэг юм.

2000 оны байдлаар, Австри улсад 186 төрлийн сонин, түүний дотор өдөр тутмын 28 сонин хэвлэгдэн гардагаас “Нойе кронен-цайтунг” сонин 1,04 сая хувиар хэвлэгддэг ба дэлхийн өдөр тутмын ууган сонины нэг болох 1703 онд үндэслэгдсэн “Винер -цайтунг” /Венийн сонин/ сонин 300 жилийн түүхтэй.

Австрийг “хөгжлийн орон” гэж дэлхий дахинаараа нэрлэдэг. Тус улсад жил бүрийн 5-р сард хагас сар гаруй үргэлжилдэг “Венийн соёлын баяр”-аас гадна сар бүр соёл урлагийн томоохон баяр болдог. Хөгжилд дуртай Австрийн ард түмний дундаас дэлхийд нэрд гарсан агуу их хөгжмийн зохиолч Й.Гайдн, В.Моцарт, Ф.Шуберт, И.Штраус нарын хөгжмийн зохиолчид төрөн гарсан бөгөөд Германы суут хөгжмийн зохиолч Л.Бетховен Венад амьдарч, алдарт бүтээл туурвилаа бүтээсэн түүхтэй. Түүнчлэн Австриас мөн суут хүмүүс төрөн гарсаны дотор Нобелийн шагналтан 15 бий. К.Маркс, А.Эйнштейн нартай нэгэн зиндаанд агуу сэтгэгч гэгддэг сэтгэцийн задлан шинжээч Зигмунд Фрейд /1856-1939/, Холливудийн алдарт жүжигчин А.Шварценгер нарын алдарт суутнууд Австрийн ард түмний дундаас төрөн гарсан билээ.

Австри жуулчлал их хөгжсөн орон. Уулын аялал, өвлийн болон усан спорт, олон арван үзэсгэлэнт нуурын хөвөөн дэх амралтын газрууд

дэлхийд нэртэй концертын олон танхим зэрэг нь гадаад, дотоодын жуулчдыг эрхгүй татдаг байна. Австрийн хүн амын бараг 50% нь цас мөсний спортоор тогтмол хичээллэж, цана тэшүүр, чаргаар гулгадаг байна. Зөвхөн Австрид цанын сургууль 500 байдаг ба мөсөн гулгуурын хиймэл талбай 1300, уулын цанаас гадна 23 мянган км урт цанын замтай юм⁹.

ИШЛЭЛ ЗҮҮЛТ

1. “Үнэн” сонин. 2003. 07.05. №133.
2. Жан Жусян. “Шизе гэго гомин зизинь” Бээжин. 1987. 97-р тал.
3. Большая Советская Энциклопедия. т.1. М., 1970. стр 93.
4. К.Lase, M.Lase. Австри. Бээжин. 2002., 7-р тал. /Хятад хэлээр/
5. Гэго гайкуан. Оужоу. Бээжин. 2002 оны 7-р сар. 21-р тал.
6. Нихон кокусай зүэ. 55-р хэвлэл. Токио. 1998. 41-р тал.
7. “Хуанчю шибao” сонин. 2003.9.9.
8. Гэго гайкуан. оу жоу. Бээжин. 2002 оны 7-р сар. 24-р тал.
9. К.Lase, M.Lase. дурдсан ном.